



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 8/2017

Мандалговь

Г Орон тооны бус зөвлөл байгуулах тухай Г


Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Монгол Улсын шадар сайдын 2017 оны “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тушаалын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- | | |
|----------------------|--|
| Зөвлөлийн дарга | -Б.Түвшинбаяр /Хууль, эрх зүйн хэлтсийн дарга/ |
| Нарийн бичгийн дарга | -С.Энхээ /Аймгийн хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэг/ |
| Гишүүдэд | -Ш.Төрбат /МХГ-ын дарга/
-Б.Мөнхжаргал /ХХААГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч/
-А.Пүрэвсүрэн /СХЗХ-ийн дарга/
-Б.Ням /Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга/
-Д.Энхтуяа /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/ |

Хоёр. Зах зээлийн шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэсэн ажил, арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөн хэрэгжилтийг ханган, сум, байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг зөвлөл /Б.Түвшинбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200594